



**МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр.  
Утас: 26 28 30, 26 61 71, Факс: (976-11) 32 09 43,  
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

2017.10.31 № 01/6824  
таний —ны № —т

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД  
Ж.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА**

Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн  
найруулгын төслийг Монгол Улсын Их хурлын 2017 оны  
5 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн чуулганаар  
батлуулан мөрдөж эхэлсэн.

Уг хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аюултай  
хог хаягдлын талаарх холбогдох журам, жагсаалтын  
төслийг боловсруулан хүргүүлж байна.

Судлан үзэж, саналаа 2017 оны 11 дугаар сарын  
10-ны дотор ирүүлнэ үү.

Хавсралт 1. Журмын төсөл ... хуудастай.

Хавсралт 2. Аюултай хог хаягдлын жагсаалтын  
төсөл ... хуудастай.

Хавсралт 3. Танилцуулга ... хуудастай.



Н.ЦЭРЭНБАТ

001318

2017. 10. 09  
85/0 1031  
2017. 10. 09  
34

Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам,  
Аюултай хог хаягдлын жагсаалт батлах тухай  
Засгийн газрын тогтоолын төслийн  
**ТАНИЛЦУУЛГА**

Хог хаягдлын тухай хууль 2017 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар шинэчилэн батлагдсан байна.

Хуулийн зорилго нь хог хаягдлааас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэнд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлын тухай хуулийн **7.1.2** болон **7.1.3-т** “аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”-ыг, “аюултай хог хаягдлын жагсаалт”-ыг Засгийн газар батална гэж заасны дагуу журам, жагсаалтуудыг боловсруулаад байна.

Хог хаягдлын тухай хуулийн **7.1.2-т** заасан аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журмыг боловсруулахдаа АНУ, Европын холбоо, Япон гэх мэт өндөр хөгжилтэй орнуудын тэргүүн туршлагыг судлан Монгол орны онцлогт тохируулан хог хаягдлын нэр төрөл, тоо хэмжээ, устгах арга, өвөл, зуны улирал дахь хог хаягдлын судалгааг ашиглан боловсруулсан болно.

Хог хаягдлын тухай хуулийн **7.1.3-т** заасан “аюултай хог хаягдлын жагсаалтыг аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам дээр тулгуурласан болно.

**Аюултай хог хаягдлын нэг жишээ дурьдахад:** Хог хаягдлын тухай хуулийн 7.1.3-т заасны дагуу Засгийн газрын тогтоолоор батлагдах энэхүү аюултай хог хаягдлын жагсаалтын төслийг Европын холбоо, АНУ болон бусад орнуудад мөрдөж буй аюултай хог хаягдлын холбогдох мэдээлэл, баримт бичгийг судлан түүн дээр үндэслэн, Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенцийн шаардлагад нийцүүлэн боловсруулаад байна.

Энэхүү жагсаалт батлагдсанаар аюултай хог хаягдлын байгаль орчинд ээлтэй менежментийн дэд бүтцийг бий болгох, хяналтыг сайжруулах нөхцөл бүрдэх болно. Мөн олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нэгэн шинэ алхам бий болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны .... дугаар

Улаанбаатар

сарын.....ны өдөр

Дугаар

Хот

Журам батлах тухай

Хог хаягдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журмыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэ тогтооюуд баталсан журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан “Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 288 дугаар тогтоол, “Журам батлах тухай” Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 135 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

У.ХҮРЭЛСҮХ

БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Н.ЦЭРЭНБАТ

Засгийн газрын 2017 оны ..... дугаар  
тогтоолын хавсралт

**Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин  
боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Хог хаягдлын тухай хуулийн 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31, 32, 33, 34, 35, 36 дугаар зүйлд заасны дагуу аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Аюултай хог хаягдал түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх, бүртгэх, тайлан мэдээ цуглуулах болон эдгээр үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах эрх зүйн хэм хэмжээг тогтоон зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.3. Цацраг идэвхт хог хаягдлыг цуглуулах, савлах, түр байршуулах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулах, хадгалахтай холбогдсон үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулахгүй.

**Хоёр. Аюултай хог хаягдал үүсгэгч болон цуглуулах, тээвэрлэх, дахин  
боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх**

2.1. Аюултай хог хаягдал үүсгэгч болон цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хүсэлт гаргаж, бүртгэлийн дугаар авна.

2.2. Энэхүү журмын 2.1-д заасан дугаарыг аваадаа байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан бүртгэлийн маягтыг бөглөж хүргүүлнэ.

2.3. Аюултай хог хаягдлыг өмчлөх эрх шилжсэн бол шинээр өмчлөгч нь энэхүү журмын 2.2-д заасны дагуу бүртгүүлнэ.

2.4. Бүртгэлийн дугаар нь үсэг бүхий 5 цифрээс бүрдэх ба үүсгэгчийн бүртгэлийн дугаар “Ү”, тээвэрлэх “Т”, цуглуулах “Ц”, дахин боловсруулах “Б”, устгах үйл ажиллагаа эрхлэгчийнх “У” үсгээр эхэлнэ. Жишээ нь: Ү00001.

**Гурав. Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалах**

3.1. Аюултай хог хаягдал үүсгэгчийг сард үүсгэж буй хог хаягдлын хэмжээгээр нь дараах хүснэгтэд заасны дагуу ангилна.

## Аюултай хог хаягдал үүсгэгчийн ангилал

1 -р хүснэгт

Үүсгэгч	Хог хаягдлын хэмжээ, кг/сар
Том	≥1000
Дунд	50-аас их буюу 1000-аас бага
Жижиг	≤50

3.2. Сард 50 кг-аас бага аюултай хог хаягдал үүсгэдэг жижиг үүсгэгчид энэ журмын 2.1 дэх заалт хамаarahгүй.

3.3. Аюултай хог хаягдал үүсгэгч нь Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлд зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ:

3.3.1. үүсэх хог хаягдлын хэмжээг бууруулах, эргүүлэн ашиглах, хоргуйжүүлэх, устгах замаар байгаль орчинд ялгарах ялгарал, бохирдуулагчийн хэмжээг бууруулах;

3.3.2. хог хаягдлыг ялгаж ангилах;

3.3.3. хог хаягдлын аюулын шинж чанар болон аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг итгэмжлэгдсэн лабораториор тодорхойлуулах;

3.3.4. өөрийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын төрөл, кодыг хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоох;

3.3.5. аюултай хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих;

3.3.6. өөрийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлаа аюулгүй устгах болон дахин боловсруулах боломжгүй бол аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулах, экспортлох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэх;

3.3.7. гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материалыг шаардлагатай газар байрлуулж, ашиглалтын бэлэн байдлыг хангах;

3.3.8. дараах мэдээллийг шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газар байрлуулах:

- аюултай хог хаягдал хариуцсан ажилтны нэр, утасны дугаар;
- гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материалын байрлалыг заасан зураг, схем;
- галын дуудлага өгөх утасны дугаар.

3.3.9. хэвийн үйл ажиллагааны үед аюултай хог хаягдалтай харьцах болон аюул ослын үед ажиллах зааварчилгааг түүнтэй харьцдаг ажилтан бүрээр боловсруулж, тэднийг сургаж, дадлагажуулах.

3.4. Аюултай эд анги агуулсан бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдан борлуулах үйл ажиллагаа эрхлэгчийг аюултай хог хаягдал үүсгэгч гэж үзэх ба дараах үүргийг хүлээнэ:

3.4.1. үйлдвэрлэсэн, худалдан борлуулсан бараа, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн схемийг гаргаж, олон нийтэд нээлттэй байлгах, сурталчлах;

3.4.2. үйлдвэрлэсэн, худалдан борлуулсан бараа, бүтээгдэхүүнээс үүсэх хог хаягдлыг цуглуулах;

3.4.3. цуглуулсан хог хаягдлыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд ээлтэй аргаар хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох эсвэл эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэх;

3.4.4. энэ журмын 3.4.2-д заасны дагуу хуучин, ашиглалтаас гарсан бараа, бүтээгдэхүүнийг цуглуулахдаа дараах аргуудаас сонгож хэрэгжүүлнэ:

3.4.4.а. шинийг худалдахдаа хуучныг нь эргүүлэн авч, үнийн хөнгөлөлт

үзүүлэх;

3.4.4.б. хуучин, ашиглалтаас гарсан бараа, бүтээгдэхүүнийг тодорхой

үнээр худалдан авах эсвэл шинэ бүтээгдэхүүн худалдан авахад хөнгөлөлт үзүүлэх, урамшуулал олгох;

3.4.4.в. худалдан борлуулах цэгүүдэд хаягдал хүлээн авах цэг, сав ажиллуулах.

3.5. Аюултай хог хаягдал хариуцсан ажилтан нь аюул осол, асгаралт, алдагдал үүссэн тохиолдолд дараах арга хэмжээг авна:

3.5.1. галын дуудлага өгөх, гал тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, боломжтой бол унтраагуур, хэрэгсэл ашиглаж галыг унтраах;

3.5.2. аюултай хог хаягдал асгарсан тохиолдолд боломжтой бол асгаралтыг зогсоох болон тархалтаас сэргийлэх арга хэмжээ авах, хог хаягдал, бохирдсон материал, хөрсийг цэвэрлэх үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх;

3.5.3. хүний эрүүл мэндэд аюул учруулахуйц галын аюул, дэлбэрэлт, асгаралт үүссэн, аюултай хог хаягдал гадаргын усыг бохирдуулсан тохиолдолд тухайн орон нутгийн онцгой байдлын газарт яаралтай мэдэгдэж, дараах мэдээллийг өгнө:

- аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, бүртгэлийн дугаар;
- аюул ослын төрөл (галын аюул, асгаралт гэх мэт), огноо, цаг хугацаа;
- аюулд өртсөн хог хаягдлын төрөл болон тоо хэмжээ;
- үүссэн аюултай нөхцөл байдал болон үүсэж болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээлэл;
- шаардагдах материал болон түүний хэмжээ.

3.6. Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр Хог хаягдлын тухай хуулийн 23.1, 23.2-д заасан хугацаагаар түр хадгална.

3.7. Аюултай хог хаягдал үүсгэгч болон өмчлөгч нь аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалахдаа дараах шаардлагыг хангасан байна:

3.7.1. аюултай хог хаягдлыг ангилан, агуулж буй хог хаягдалтайгаа урвалд ордоггүй материалыар хийсэн эсвэл ийм материалыар доторлосон саванд савлах;

3.7.2. энэ журмын 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан нөхцөлд хадгалах;

3.7.3. аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн нэр, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил

харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байх.

3.8. Үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаар бүртгэл хөтлөх ба бүртгэлийг аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, устгах, дахин боловсруулах, экспортлох зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлснээр дуусгавар болгож, дахин эхлэх үед шинээр эхэлнэ.

3.9. Үүсгэгч болон өмчлөгч нь шүүрлийн шингэн цуглуулах системд хуримтлагдсан шингэнийг хамгийн багадаа 90 хоногт 1 удаа цэвэрлэж, бүртгэл хөтлөх ба үүссэн хаягдлыг устгах зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлнэ.

3.10. Үүсгэгч болон өмчлөгч нь аюултай хог хаягдлыг аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах, устгах, экспортлох зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлэхдээ байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагын баталсан маягтын дагуу аюултай хог хаягдлын дагалдах бичгийг бүрдүүлж, бүртгэл хөтөлнө.

3.11. Үүсгэгч болон өмчлөгч нь энэ журмын 3.10-д заасан дагалдах бичгийг дөрвөн хувь үйлдэх ба өөрөө болон тээвэрлэгч гарын үсэг зурж баталгаажуулсны дараа нэг хувийг өөртөө үлдээн бусад гурван хувийг тээвэрлэгчид хог хаягдлын хамт хүлээлгэн өгнө.

3.12. Тээвэрлэгч энэ журмын 3.11-д заасан гурван хувь хог хаягдлын дагалдах бичгийг хог хаягдал хүлээн авагчид хог хаягдлын хамт хүргэж, гарын үсэг зуруулж баталгаажуулсан, нэг хувийг хог хаягдал хүлээн авагчид, нэг хувийг тээвэрлэгч өөртөө үлдээнэ. Гурав дахь хувийг үүсгэгчид эргүүлж хүлээлгэн өгнө.

3.13. Үүсгэгч нь энэ журмын 3.12-д заасан өөртөө үлдээсэн хог хаягдлын дагалдах бичгийг тээвэрлэгчийн хүлээн авагчаар гарын үсэг зуруулж баталгаажуулсан хог хаягдлын дагалдах бичгийн хувийг хүлээн автал хадгална.

3.14. Үүсгэгч нь дараах баримт материалыг хамгийн багадаа гурван жил хадгална:

3.14.1. энэ журмын 3.12-д заасан гарын үсэг зурж баталгаажсан хог хаягдлын дагалдах бичиг;

3.14.2. үүсгэсэн болон тээвэрлүүлсэн хог хаягдлын бүртгэл, тайлан.

## **Дөрөв. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх**

4.1. Аюултай хог хаягдал тээвэрлэх үйл ажиллагаа явуулахад Хог хаягдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлд зааснаас гадна дараах журмыг мөрднө:

4.1.1. Тээвэрлэгч нь үүсгэгч болон өмчлөгчтэй байгуулсан гэрээний үндсэн зориулалтын саванд савласан, 3.7.3-д заасан тэмдэг, тэмдэглэгээ, 3.10-д заасан хог хаягдлын дагалдах бичиг бүхий аюултай хог хаягдлыг үүсгэгчээс хүлээн авч тээвэрлэнэ.

4.1.2. Тээвэрлэгч нь үүсгэгчийн огноо, гарын үсэг зурж баталгаажуулсан хог хаягдлын гурван хувь дагалдах бичгийг бүрэн, үнэн зөв бөглөгдсөн эсэхийг шалган, гарын үсэг зурж хүлээж авна.

4.1.3. Тээвэрлэгч нь үүсгэгчээс хүлээн авсан аюултай хог хаягдлыг бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг ханган тээвэрлэж, дагалдах бичигт заасан аж ахуйн нэгж, иргэнд хүлээлгэж өгнө.

4.1.4. Тээвэрлэлт дууссны дараа энэ журмын 3.12-д заасны дагуу хүлээн авагчийн гарын үзэг зурж баталгаажуулсан хог хаягдлын дагалдах бичгийн нэг хувийг үүсгэгчид буцаан өгч, нэг хувийг өөртөө авна.

4.1.5. Үүсгэгч болон өмчлөгчийн буруутай үйл ажиллагааны улмаас энэ журмын 7.1.5, 7.1.6, 7.1.7 –д заасан нөхцөл байдал үүссэн тохиодолд хүлээн авагч уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзвал шинээр хог хаягдлын дагалдах бичгийг энэ журмын 3.10, 3.11-д заасны дагуу бүрдүүлнэ.

4.1.6. Хүлээн авагч хог хаягдлыг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд, түүний хог хаягдлыг хүлээн авахаас татгалзсан тухай бичгээр гаргасан тайлбарыг хог хаягдлын дагалдах бичгийн хамт үүсгэгчид хүлээлгэн өгнө.

4.1.7. Хэрэв тээвэрлэлтийг нэгээс дээш тээвэрлэгч (жишээ нь, авто болон төмөр замын холимог тээвэр) гүйцэтгэж байгаа бол тээвэрлэлтийг гүйцэтгэсэн тээвэрлэгч бүр гарын үсэг зурж баталгаажсан хог хаягдлын дагалдах бичгийг хог хаягдлын хамт дараагийн тээвэрлэгчид хүлээлгэн өгнө. Эцсийн тээвэрлэгчээс бусад тээвэрлэгчид зөвхөн хог хаягдлын дагалдах бичгийн хуулбарыг өөртөө үлдээнэ. Эцсийн тээвэрлэгч эх хувийг энэ журмын 3.12-д заасны дагуу баталгаажуулж, үүсгэгчид хүлээлгэн өгнө.

4.1.8. Тээвэрлэгч нь өөрт үлдсэн хог хаягдлын дагалдах бичгийг хамгийн багадаа гурван жил хадгална.

4.2. Аюултай хог хаягдлыг тээврийн хэрэгсэлд ачихад дараах шаардлагыг мөрдлөг болгоно:

4.2.1. тээвэрлэлтийн явцад аюултай хог хаягдал унаж, асгарч алдагдахгүй байхаар хөдөлгөөнгүй, жигд тархалттайгаар байршуулж тээвэрлэх;

4.2.2. том овортой сав баглаа боодолтой аюултай хог хаягдлыг тээврийн хэрэгсэлтэй бат бөх бэхэлсэн байх ба шингэн бодисын хувьд хазайх, тойрох үед тэнцвэр хадгалагдаж байхаар савалгааны дүүргэлтийг тохируулах;

4.2.3. аюултай хог хаягдалтай савны амыг дээш харуулж байрлуулах.

4.3. Аюултай хог хаягдлын тээвэрлэхэд дараах шаардлагыг мөрдлөг болгоно:

4.3.1. авто тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг зөвхөн өдрийн цагаар тээвэрлэх;

4.3.2. авто тээврийн хэрэгслийн хурдыг 50 км/цаг-аас хэтрүүлэхгүй байх;

4.3.3. цуваагаар тээвэрлэх тохиолдолд автомашин хоорондын зайд тал газрын замд 50 метрээс багагүй, уулын замд 300 метрээс багагүй байна.

4.4. Аюултай хог хаягдлыг техникийн бүрэн бүтэн байдал хангасан, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

4.5. Аюултай хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч аюулгүй ажиллагааны талаар сургалтанд хамрагдсан байна.

4.6. Тээвэрлэгч нь тээврийн хэрэгслийг аюултай хог хаягдал асгарах, алдагдах үед ашиглах багаж хэрэгсэл, материалаар хангах ба тээврийн хэрэгслийн жолооч нь эдгээрийг ашиглах сургалтанд хамрагдаж, дадал эзэмшсэн байна.

4.7. Тээвэрлэлтийн үед аюултай хог хаягдал асгарвал дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.7.1. үүсгэгчид яаралтай мэдэгдэж, холбогдох зааварчилгааг авах;

4.7.2. тухайн орон нутгийн онцгой байдлын албанд мэдэгдэж дараах мэдээллийг өгөх:

- аюул осол болсон газрын байршил, огноо, цаг хугацаа;
- аюулд өртсөн хог хаягдлын төрөл болон тоо хэмжээ;
- үүсэж болзошгүй аюултай нөхцөл байдал болон үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээлэл;
- шаардагдах материал болон түүний хэмжээ.

4.8. Тээвэрлэгч нь аюултай хог хаягдал асгарсан талаар доорх мэдээлэл агуулсан тайланг 30 хоногийн дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад хүргүүлнэ:

- тайлан гаргагчийн нэр, хаяг, утасны дугаар;
- аюултай хог хаягдал асгарсан газрын нэр, байршил болон огноо;
- асгарсан алдагдсан аюултай хог хаягдлын нэр, ангилал;
- тээвэрлэж явсан хэмжээ, асгарсан аюултай хог хаягдлын хэмжээ;
- асгарч алдагдах болсон шалтгаан;
- нөлөөлөлд өртсөн, хордсон хүний тоо;
- бохирдолд өртсөн хөрс, ус, барилга байгууламжийн хэмжээ, талбай;
- ослын үед авсан арга хэмжээ, түүнийг хариуцаж хэрэгжүүлсэн хүний нэр, хаяг.

4.9. Асгарсан хог хаягдлыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй түвшинд хүртэл цэвэрлэх арга хэмжээг авах ба холбогдон гарах зардлыг буруутай эдгээд хариуцна.

4.10. Тээвэрлэгч нь тухайн жил тээвэрлэсэн аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”-д заасан хугацаанд, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан аюултай хог хаягдал тээвэрлэх үйл ажиллагааны тайлангийн маягтын дагуу гаргаж журамд заасан байгууллагад хүргүүлнэ.

#### **Тав. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах**

5.1. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа явуулж буй байгууламж нь Хог хаягдлын тухай хуулийн 25.3-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

5.1.1. Байгууламж нь аюулгүй ажиллагааны дараах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна:

- аюул ослын үед дохио өгөх дохиоллын болон дотоод холбооны систем;
- аюул ослын үед яаралтай тусlamж дуудах зориулалттай орон нутгийн цагдаагийн болон онцгой байдлын байгууллагатай шууд холбоо барих утас;
- зөөврийн галын хор, гал унтраах тоноглол (хөөс, инертийн хий, хуурай химийн бодис гэх мэт зориулалтын гал унтраах тоноглол), асгарсан шингэний урсалтыг хязгаарлах тоноглол, хоргүйжүүлэх тоног төхөөрөмж бодис материал;
- хангалттай хэмжээгээр даралтай ус өгөх боломжтой хоолой, хөөс үүсгэгч тоног төхөөрөмж, ус бороожуулагч систем.

5.2. Аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь Хог хаягдлын тухай хуулийн 26 дугаар зүйлд зааснаас гадна дараах шаардлагын дагуу ажиллана:

5.2.1. энэ журмын 5.1.1-д заасан тоног төхөөрөмж, хэрэгслийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор ажиллагааг шалгаж туршин, засвар үйлчилгээг тогтмол хийж, тэмдэглэл хөтөлсөн байна.

5.2.3. өөрийн байгууламжийн талаар дараах мэдээллийг орон нутгийн байгууллагуудад танилцуулсан байна:

а/ орон нутгийн цагдаа, онцгой байдлын албанд өөрийн байгууламжийн бүтэц, үйл ажиллагаа, устгаж, боловсруулж байгаа хог хаягдлын шинж чанар, гарч болзошгүй аюул осол, ажиллагсдын ажлын байрны байршил, байгууламжийн доторх орц гарц, зам, ослын гарц зэргийг талаар;

б/ орон нутгийн эмнэлгийн ажиллагсдад устгаж, боловсруулж байгаа хог хаягдлын шинж чанар, галын аюул, дэлбэрэлт болон аюултай хог хаягдал алдагдах үед гарч болзошгүй өвчлөл, гэмтэл, хордлогын талаар.

5.2.4. дараах байгууллагуудтай осол, аюулын үед хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана:

- орон нутгийн цагдаа;
- орон нутгийн онцгой байдлын газар;
- орон нутгийн эрүүл мэндийн байгууллага;
- тоног төхөөрөмж нийлүүлэгч.

5.2.5. хэрэв энэ журмын 5.2.4-д заасан гэрээг байгуулахыг тухайн байгууллага татгалзвал аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь татгалзсан шалтгааны талаар бичгээр хариу авсан байх эсвэл тэмдэглэл хөтөлж, татгалзсан этгээдээр гарын үсэг зуруулж баталгаажуулсан байна.

5.2.6.“Аюултай. зөвшөөрөлгүй гадны хүн орохыг хориглоно” гэсэн анхааруулгыг ерөнхий хаалга болон дотоод байгууламж бүрийн хаалга нэг бүр дээр хамгийн багадаа 10 м-ийн зайнаас харагдахуйц байхаар байрлуулсан байна.

5.2.7. тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа алдагдах, эвдрэх гэмтэх болон ажилтны буруутай үйл ажиллагаанаас байгаль орчинд аюултай хог хаягдал алдагдах, хүний эрүүл мэндэд аюул учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор дараах ажиллагаанд хяналт тавих төлөвлөгөөг боловсруулж, байгууламжийн даргаар батлуулсан байна:

а/ технологийн тоног төхөөрөмжийн ажиллагаа;  
б/ аюул ослын үед ажиллах тоног төхөөрөмж тоноглол, дохиоллын системийн ажиллагаа;  
хэмжээ авах зориулалттай хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны

тоног төхөөрөмж тоноглол, дохиоллын системийн ажиллагаа;

в/ аюул ослын үед ажиллах тоног төхөөрөмж тоноглол, дохиоллын системийн ажиллагаа;

г/ашиглалтын болон барилгын бүтэц хэсгийн (далан суваг, хураагуур

гэх

мэт) бүрэн бүтэн байдал.

5.2.8. энэ журмын 5.2.7-д заасан төлөвлөгөө нь эвдрэл, гэмтэл гарах болон чанар байдал нь алдагдсанаас үүсэж болох бүх эрсдлийн (далан суваг идэгдэх, шингэн алдагдах) жагсаалтыг агуулсан байх ба хяналт шалгалт хийх үед түүний дагуу шалгалтыг хийнэ.

5.2.9. энэ журмын 5.2.7-д заасан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийх хугацааг (тухайн үйлдэл бүрийн үед, өдөр бүр, сард гэх мэт) тухайн тоног төхөөрөмжийн элэгдэлд өртөх хугацаа, хэвийн ажиллагаа алдагдах, эвдрэл гэмтэлд өртөх магадлал, хүний буруутай үйл ажиллагаатай холбоотойгоор эрсдэл үүсэх магадлал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн зэрэг зэргээс хамааруулан тогтооно.

5.2.10. хяналт шалгалт хийх үед дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, дүгнэлт гаргах ба уг бүртгэл, дүгнэлтийг шалгалт хийсэн өдрөөс хойш хамгийн багадаа 3 жил хадгална.

5.2.11. энэ журмын 5.2.10-д заасан бүртгэл, дүгнэлтэд хяналт шалгалт хийсэн огноо, гүйцэтгэсэн хүний нэр, хийсэн ажиглалтын талаарх тэмдэглэл, илэрсэн зөрчлийг арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.

5.2.12. хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг яаралтай авна.

5.2.13. дараах жагсаалт, тодорхойлолтыг гаргаж, байгууламжийн даргаар батлуулсан байна:

- аюултай хог хаягдалтай харьцдаг ажлын байр болон түүн дээр ажилладаг ажиллагсдын жагсаалт;
- ажлын байр нэг бүрээр ажлын тодорхойлолт.

5.3. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах байгууламжийн ажилтан нь тухайн ажлын байрны шаардлагад нийцсэн сургалтанд хамрагдсан байна. Сургалт нь танхимын болон ажлын байран дээр дадлагажуулах сургалт гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

5.4. Энэ журмын 5.3-д заасан сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг багтаасан байна:

- аюултай хог хаягдалтай харьцах болон тухайн ажлын байранд ажиллах заавар;
- хяналтын болон авран хамгаалах багаж хэрэгслийг ашиглах, шалгах, засварлах, солих заавар;
- технологийн гол параметрүүдийг хянах;
- холбоо болон дохиоллын системийг ашиглах заавар;
- галын аюул болон дэлбэрэлт үүссэн үед ажиллах заавар;
- газрын доорх ус бохирдсон тохиолдолд ажиллах заавар;
- системийг унтраах, зогсоох заавар.

5.5. Энэ журмын 5.3-д заасан сургалтын үргэлжлэх хугацаа 3 сараас багагүй байна.

5.6. Сургалтанд хамрагдсан ажилтныг жил бүр давтан сургалтанд хамруулна.

5.8. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулах хэмжээгээр агаар, хөрс, усанд санамсаргүй болон санаатайгаар аюултай хог хаягдал алдах болон тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах үед үүсэх эрсдлийг хамгийн бага хэмжээнд хүртэл буруулах зорилго бүхий аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөтэй байна.

5.9. Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөнд аюул, осол үүсэх үед байгууламжийн ажилтнуудын авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үүргийг тодорхойлсон байна.

5.10. Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөнд дараах жагсаалтыг хавсаргасан байна:

5.10.1. онцгой байдлын зохицуулагчаар томилогдсон хүмүүсийн нэр, хаяг, гэрийн болон ажлын утасны дугаар, гар утасны дугаар;

5.10.2. аюул, ослын үед ашиглах тоног төхөөрөмж хэрэгсэлийн жагсаалт (гал унтраах, асгаралтыг хянах, холбоо дохиоллын систем, хоргүйжүүлэх, саармагжуулах тоног төхөөрөмж хэрэгсэл гэх мэт);

5.10.3. энэ журмын 5.1.1-д заасан жагсаалтад орсон тоног төхөөрөмж хэрэгсэл нэг бүрийн гадаад дурс хэлбэр болон тэдгээрийн байршлыг заасан бүдүүвч зураг.

5.11. Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөнд шаардлагатай тохиолдолд байгууламжийн ажилтан болон ойр орчмын байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, оршин суугч иргэд, мал, гэрийн тэжээвэр амьтныг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг оруулсан байна.

5.13. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэлт эхлэх үед ажиллах дохиолол, нүүлгэн шилжүүлэх зам, гарц, аюулд өртсөн тохиолдолд ашиглах нэмэлт гарц зэргийг заасан байна.

5.14. Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг аюул, ослын үед хамтран ажиллахаар гэрээ байгуулсан орон нутгийн цагдаа, онцгой байдлын газар, эмнэлэг болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зэрэг бусад гэрээ байгуулсан байгууллагуудад хүргүүлж, танилцуулна.

5.15. Дараах тохиолдолд аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг шинэчилж, батлуулна:

- а/ үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдхөх;
- б/ аюул, ослын үед уг төлөвлөгөөг ашиглаж ажиллагаа явуулахад шаардлага хангагүй;
- в/ байгууламжийн загвар, барилга байгууламж, үйл ажиллагаа өөрчлөгдхөх;
- г/ ашиглалтын горимд өөрчлөлт орсон болон бусад өөрчлөлт (гал, тэсрэх аюул үүсгэх, аюултай хог хаягдал алдагдах боломжтой хог хаягдлын хэмжээ ихэссэн);
- д/ аюул, ослын үед авах арга хэмжээ өөрчлөгдсөн;
- е/ онцгой байдлын зохицуулагч өөрчлөгдсөн;
- ё/ аюул, ослын үед ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, материал өөрчлөгдсөн.

5.16. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн онцгой байдлын зохицуулагч болон түүнийг эзгүй үед орлох этгээдийг томилно.

5.17. Онцгой байдлын зохицуулагч нь дараах баримт материалыг бүрэн сайн судалж, ашиглах болон ажиллах дадлыг эзэмшсэн байна:

- 5.7.1. аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө;
- 5.7.2. байгууламжийн техник, технологи, үйл ажиллагаа;
- 5.7.3. аюултай хог хаягдлын шинж чанар болон байрлал;
- 5.7.4. байгууламжийн бүх бүртгэл, бичлэгийн байршил;
- 5.7.5. байгууламжийн дотоод зохион байгуулалт, байршил.

5.18. Онцгой байдлын зохицуулагч нь аюул, ослын үед дараах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлнэ:

- а/ байгууламжийн дохиолол, холбооны системийг ажиллуулах;
- б/ улсын болон орон нутгийн онцгой байдлын газарт шаардлагатай бол мэдэгдэх;

в/ аюул, ослын үед аюулын шинж чанар, эх үүсвэр, тоо хэмжээ, цар хүрээг тодорхойлох;

г/ хүлээн авсан, боловсруулсан, устгасан аюултай хог хаягдлын бүртгэл, хяналт-шинжилгээний бичлэг, химиин шинжилгээний дүн зэргийг хянаж үзэх;

д/ ослын үед үүсэж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулж болзошгүй аюулыг үнэлэх. Ингэхдээ аюултай хог хаягдал алдагдах, галын болон дэлбэрэлтийн үед шууд болон шууд бусаар үүсэх аюулын аль алиныг авч үзнэ (хортой, идэмхий, амьсгал боогдуулагч хий үүссэнээс үзүүлэх нөлөө, гал унтраах болон дэлбэрэлтийн үед үүссэн дулааныг бууруулахад ашигласан ус болон химиин бодисоос үүссэн урсац гадаргын усанд хортой нөлөө үзүүлэх гэх мэт).

5.19. Хэрэв байгууламжид үүссэн аюул, ослоос байгууламжийн гаднах хүн ам, байгаль орчинд хор аюул үзүүлэхээр байгааг онцгой байдлын зохицуулагч тогтоовол дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

5.19.1. нүүлгэн шилжүүлэх шаардлагатай гэж үзвэл яаралтай орон нутгийн

болон улсын онцгой байдлын газарт мэдэгдэх;

5.19.2. дээрх мэдэгдлийг хийхдээ дараах мэдээллийг өгнө:

- өөрийн нэр, утасны дугаар;
- байгууламжийн нэр, хаяг;
- аюул ослын төрөл (гал, хаягдал алдагдах гэх мэт);
- гарсан хугацаа;
- аюул үүсгэсэн материалын нэр төрөл, тоо хэмжээ, тархалт;
- хор аюулын цар хүрээ;
- байгууламжийн гаднах хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж болох аюул.

5.20. Аюул, осол гарсан үед онцгой байдлын зохицуулагч нь бусад хог хаягдал гал болон дэлбэрэлтэд өртөх, асгарч алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор технологийн процесс, үйл ажиллагааг зогсоо, асгарсан хог хаягдлыг цуглуулах, савлах, савласан хаягдлыг зөөх, тусгаарлах гэх мэт боломжтой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.21. Хэрэв үүсэж болох аюулаас урьдчилан сэргийлж технологийн процессыг зогсоосон бол онцгой байдлын зохицуулагч нь даралт нэмэгдэх, асгаралт, алдагдал үүсэх, хий үүсэх, хавхаг хаалт, шугам хоолой болон бусад тоног төхөөрөмжид гэмтэл гарахаас урьдчилан сэргийлж, хяналт тавина.

5.22. Аюул, осол гарсны дараа онцгой байдлын зохицуулагч нь асгарсан хаягдал, бохирдсон хөрс, ус болон бусад бохирдсон материалыг яаралтай цэвэрлэх, савлах, устгах арга хэмжээг авна.

5.23. Онцгой байдлын зохицуулагч нь байгууламжийн аюул осолд өртсөн талбайд дараах хяналтыг тавина:

5.23.1. цэвэрлэх үйл ажиллагаа дуустал цэвэрлэж, савлаж, устгаж байгаа хог хаягдалтай нийцэхгүй хаягдал байгаа эсэх;

5.23.2. осол аюулын үед ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг цэвэрлэж, зохих байрлалд нь тавьсан эсэх.

5.24. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь осол аюулын үед ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага гарсан тохиолдол бүрт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, цаг хугацаа зэргийг

тэмдэглэж, аюул осол тохиолдсоноос хойш 15 хоногийн дотор дараах мэдээлэл бүхий тайланг орон нутгийн онцгой байдлын газарт хүргүүлнэ:

5.24.1. аюултай хог хаягдал устгах, хадгалах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгчийн нэр, хаяг, утасны дугаар;

5.24.2. байгууламжийн нэр, хаяг, утасны дугаар;

5.24.3. осол аюулын төрөл, гарсан огноо, цаг;

5.24.4. өртсөн материалын нэр, тоо хэмжээ;

5.24.5. аюулд өртсөн цар хүрээ;

5.24.6. хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх бодит болон болзошгүй аюулын үнэлгээ;

5.24.7. осол аюулын үед үүссэн материалын (бохирдсон ус, бодис шингэсэн материал гэх мэт) тоо хэмжээ, төлөв байдал;

5.24.8. авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.

5.25. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь шатамхай, урвалын идэвхтэй, нийцгүй хог хаягдлыг бусад хог хаягдлаас тусад хадгалах ба түүний ойролцоо ил гал гаргах, тамхи татах, гагнуур хийх, металл тасдах үйл ажиллагаа явуулах болон үрэлтээс үүсэх дулаан, оч (статик, цахилгаан, механик оч), өөрөө урвалд орж халдаг бодис, цацрагийн дулаан, халуун гадаргуу зэрэг эх үүсвэртэй ойр байршуулахыг хориглоно.

5.26. Шатамхай, урвалын идэвхтэй болон нийцгүй хог хаягдалтай харьцах газруудад “Тамхи татахыг хориглоно”, “Ил гал гарахыг хориглоно” гэсэн анхааруулгыг харагдахуйц газар байрлуулсан байна.

5.27. Шатамхай, урвалын идэвхтэй болон нийцгүй аюултай хог хаягдал дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь ажлын байрны аюулгүй байдал хангасан, дараах нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх арга хэмжээ авсан байгууламжид үйл ажиллагаа явуулна:

5.27.1. гэнэтийн халалт, гал, тэсрэлт үүсэх болон даралт нэмэгдэх, эрчимтэй урвалжих;

5.27.2. хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөл учруулахуйц хэмжээгээр хортой уур, манан, тоос, хий хяналтгүй үүсэх;

5.27.3. галын болон тэсрэлт үүсгэх хэмжээгээр шатамхай уур, хий хяналтгүй үүсэх;

5.27.4. байгууламж болон тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал алдагдах, гэмтэл гарах;

5.27.5. хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөтэй шингэн хяналтгүй алдагдах.

### **Зургаа. Аюултай хог хаягдлыг хүлээн авах**

6.1. Аюултай хог хаягдал хүлээн авахад Хог хаягдлын тухай хуулийн 27 дугаар зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг дагуу ажиллана:

6.1.1. аюултай хог хаягдал хүлээн авагч нь дагалдах бичиг бүхий аюултай хог хаягдлыг хүлээж аваад, дагалдах бичгийн хувь бүр дээр гарын үсэг зурж, хүлээж авсан огноог тэмдэглэнэ.

6.1.2. хог хаягдлын дагалдах бичгийн хувь нэг бүрийг сайтар шалгаж, үл зохицол байгаа эсэхийг нягтална. тээвэрлэгчид гарын үсэг зурсан хог хаягдлын дагалдах бичгийн 1 хувийг эргүүлж өгнө.

6.1.3. хүлээн авагч нь хог хаягдлыг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор үүсгэгчид гарын үсэг зурсан хог хаягдлын дагалдах бичгийг хүргүүлнэ.

6.1.4. хог хаягдлыг хүлээж авснаас хойш 3 жилийн хугацаанд хог хаягдлын дагалдах бичгийг хадгална.

6.2. Дараах тохиолдлыг хог хаягдлын дагалдах бичигт үл зохицол үүссэн гэж үзнэ:

6.2.1. хог хаягдлын төрөл, тоо хэмжээ нь дагалдах бичгээс зөрүүтэй байх;

6.2.2. хог хаягдлыг байгууламж хүлээн авах боломжгүй хэмжээнд хэт дүүрэн эсвэл бага ачилттай;

6.2.3. хоосон сав гэж ирсэн хаягдал дахь бүтээгдэхүүний үлдэгдэл нь энэхүү журмын 6.7-д заасан “хоосон” сав гэж үзэх хэмжээнээс их.

6.3. Дараах тохиолдлыг хог хаягдлын тоо хэмжээний үл зохицол гэж үзнэ:

6.3.1. хаягдлын жингийн зөрөө 5%-аас (жингийн) их;

6.3.2. савлагаатай хаягдлын хувьд 1 тэвшин дэх торхны тооны зөрөө 1 болон түүнээс их.

6.4. Дараах тохиолдлыг хог хаягдлын төрлийн үл зохицол гэж үзнэ:

6.4.1. үзлэг болон химийн шинжилгээгээр нэр төрөл нь тохирохгүй байгаа нь тогтоогдох;

6.4.2. хог хаягдлын дагалдах бичигт аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг мэдүүлээгүй байх.

6.5. Хог хаягдлын жин болон төрөлд үл зохицол илэрвэл хүлээн авагч үүсгэгч болон тээвэрлэгчтэй харилцаж шалтгааныг тодорхойлох ба үүнтэй холбогдон гарах зардлыг буруутай этгээд хариуцна.

6.6. Хүлээн авагч нь аюултай хог хаягдлыг хүлээн авч, савнаас сулласны дараа хог хаягдлыг агуулж байсан сав нь энэ журмын 6.7, 6.8, 6.9-д тавьсан шаардлагыг хангахгүй байвал үүсгэгчтэй зөвлөлдөж, савыг суллах боломжтой аргыг сонгоно.

6.7. Шахсан хий болон онцгой хортой химийн бодисоос бусад аюултай хог хаягдал савласан сав болон дотоод давхар савлагааны уутыг дараах тохиолдолд хоосон гэж үзнэ:

6.7.1. доторх бүх хаягдлыг нь сулалж юулж авсан;

6.7.2. савны болон дотоод давхар савлагааны уутны ёроолд 2,5 см-ээс ихгүй

үлдэгдэл үлдсэн;

6.7.3. савны эзлэхүүн 450 л-тэй тэнцүү буюу бага байвал савны нийт багтаамжийн 3%-иас (жингийн) ихгүй үлдэгдэл сав болон дотоод давхар савлагааны уутанд үлдсэн;

6.7.4. савны эзлэхүүн 450 л-ээс их байвал нийт багтаамжийн 0.3%-иас (жингийн) ихгүй үлдэгдэл сав болон дотоод давхар савлагааны уутанд үлдсэн.

6.8. Шахсан хий агуулсан савны дотоод даралт атмосферийн даралттай ойролцоо болсон тохиолдолд хоосон гэж үзнэ.

6.9. Онцгой хортой химийн бодис савласан савыг дараах тохиолдолд хоосон гэж үзнэ:

6.9.1. тухайн аюултай хог хаягдлыг зайлцуулах чадвар бүхий бодисын уусмалаар 3 удаа зайлж угаасан;

6.9.2. савны болон дотоод давхар савлагааны уутыг аюултай хог хаягдал үүсгэгчийн санал болгосон эсхүл шинжлэх ухааны ном зохиолд бичсэн аргаар цэвэрлэсэн;

6.9.3. агуулж буй химиин бодисоос савны ханыг бүрэн тусгаарласан дотоод давхар савлагаатай хаягдлыг дотоод савлагааны савны хамт авч сулласан.

### **Долоо. Үйл ажиллагааны бүртгэл хөтлөх**

7.1. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааны бүртгэлийг Хог хаягдлын тухай хуулийн 28 дугаар зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг дагуу хөтөлнө:

7.1.1. аюултай хог хаягдал дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь үйл ажиллагааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг тогтмол хөтөлнө.

7.1.2. энэ журмын 7.1.1-д заасан тэмдэглэлд дараах мэдээллийг оруулах ба уг тэмдэглэлийг хуульд заасан хугацаагаар хадгална:

а/ хүлээж авсан аюултай хог хаягдлын тодорхойлолт, тоо хэмжээ, түүнийг устгасан, боловсруулсан, хадгалсан арга, огноо;

б/ байгууламжийн доторх хог хаягдал нэг бүрийн байрлал, тоо хэмжээ болон хог хаягдлын дагалдах бичгийн дугаар. ландфиллд булах, хадгалах үйл ажиллагаа явуулж буй байгууламжийн хувьд газрын зураг эсвэл бүдүүвч зураг дээр аюултай хог хаягдал нэг бүрийн байршил, тоо хэмжээг тэмдэглэнэ.

в/ шинжилгээний дүн, туршилтын дүн.

г/ аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлсэн аюул осол нэг бүрийн тайлан.

д/ энэ журмын 5.2.10-д заасан хяналт шалгалтын тэмдэглэл, үр дүн.

е/ хяналт-шинжилгээ болон шинжилгээний дүн (барилга байгууламж, тоног төхөөрөмж (шингэн хадгалах сав, шугам хоолой гэх мэт), хаягдлын овоолго, газрын доорх ус, хөрс, ландфиллын шүүрэл, шатаах зуухны ялгарал, үйл ажиллагаа, тоног төхөөрөмжөөс агаарт ялгарах ялгарал гэх мэт).

### **Найм. Хяналт-шинжилгээ хийх**

8.1. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь Хог хаягдлын тухай хуулийн 30 дугаар зүйлд зааснаас гадна дараах шаардлагын дагуу хяналт-шинжилгээ хийнэ:

8.1.1. Газрын доорх усны хяналт-шинжилгээний цооног нь газрын гадаргаас доош босоо чиглэлд газрын доорх усны дээд үе хүртэл үргэлжилсэн байна.

8.1.2. Газрын доорх усны цооног гаргах зөвшөөрлийг тухайн орчны газрын доорх усны суурь судалгаа, цооногийн гүний болон байршлын зураг төсөлд үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

8.1.3. Газрын доорх усны хяналт-шинжилгээний үргэлжлэх хугацаа нь тухайн байгууламжийн үйл ажиллагаа эхлүүлэх зөвшөөрөл авсан өдрөөс байгууламжийг хааж дуусах хүртэл байна.

8.1.4. Байгууламжийн газрын доорх усны хяналт-шинжилгээний систем нь газрын доорх усны хамгийн дээд үеэс дээж авах боломжийг хангасан гүнтэй, тогтоосон цэгт гаргасан, хангалттай тооны хяналтын худагтай байна.

8.1.5. Газрын доорх усны хяналтын худгаас дээж авах бүрдээ газрын доорх усны түвшинг хэмжиж бүртгэл хөдөлнө.

8.1.6. Байгууламжийн хилээс 1500 метрийн радиус дахь гүний худаг болон гадаргын усанд хяналт-шинжилгээг Хог хаягдлын тухай хуулийн 30.1-д заасан хяналт-шинжилгээний болон хариу арга хэмжээний хөтөлбөрийн дагуу хийнэ.

8.2. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь Хог хаягдлын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу байгууламжийг хаах ба хаасны дараа мөн хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу хаалтын дараах хяналт-шинжилгээ хийнэ

8.3. Байгууламжийг хааснаас хойш хаалтын дараах хяналт-шинжилгээг дараах чиглэлээр хийж, тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ:

8.3.1. байгууламжийн бүрэн бүтэн байдал;

8.3.2. шүүрэл ялгарч буй эсэх;

8.3.3. газрын доорх усны хяналт-шинжилгээ.

8.4. Байгууламжийг хааснаас хойш газрын доорх усны хяналт-шинжилгээг, дараалсан 3 жилийн турш газрын доорх усны чанар стандартын шаардлага хангаж байгааг нотолсон тохиодолд зогсоно.

8.5. Хяналт-шинжилгээгээр ялгарал, шүүрэл илэрсэн тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, нөлөөллийг арилгах арга хэмжээг авна.

8.6. Хог хаягдлын тухай хуулийн 32.6-д заасан зардлыг итгэлцлийн санд байгуулж төвлөрүүлэхэд дараах шаардлагыг мөрдөнө:

8.6.1. нийт зардлыг тухайн байгууламжийн ажиллах жилд хувааж нэг жилд ноогдох хэмжээг тогтооно.

8.6.2. эхний жилд ноогдох зардлыг анхны хог хаягдлаа хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор, дараагийн жилүүдэд өмнөх жилийн зардал дансанд төвлөрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор тус тус итгэлийн санд төвлөрүүлнэ.

8.6.3. энэ журмын 8.6.1-д заасан зардлыг тухайн жилийн инфляцийн коэффициентээр үржүүлж тооцно

8.7. Хог хаягдлын тухай хуулийн 32.6-д заасан зардлыг барьцаа хөрөнгө байршуулж төвлөрүүлэхэд дараах шаардлагыг мөрдөнө:

8.7.1. нийт зардлыг анхны хог хаягдлаа хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор барьцаа хөрөнгөний дансанд байгууламжийг хаах хүртэлх хугацаагаар зарцуулах эрхгүйгээр байршуулна.

8.8. Энэ журмын 8.6.2, 8.7.1-д заасан дансанд төвлөрсөн хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулахтай холбогдсон үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан гэрээгээр зохицуулна.

#### **Ес. Аюултай хог хаягдал хадгалахад тавигдах нэмэлт шаардлага**

9.1. Аюултай хог хаягдал хадгалахад Хог хаягдлын тухай хуулийн 33 дугаар зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг мөрдөнө:

9.1.1. аюултай хог хаягдлыг юулэх болон нэмэхээс бусад тохиолдолд савыг байнга таглаж битүү байлгана.

9.1.2. аюултай хог хаягдал савласан савыг онгойлгох, зөөх, ачиж, буулгах, хадгалахдаа эвдэрч гэмтэх, хог хаягдал асгарахаас сэргийлж болгоомжтой харьцана.

9.1.3. аюултай хог хаягдал хадгалах сав байрлаж буй газарт 7 хоногт 1 удаа шалгалт хийж, асгаралт алдагдал, эвдрэл гэмтэл, элэгдэл зэврэлт гарсан эсэхийг тогтооно.

9.2. Аюултай шингэн хог хаягдал хадгалах сав байрлуулах талбай нь дараах шаардлагыг хангасан хязгаарлалтын системтэй байна:

9.2.1. хязгаарлалтын системийн суурь нь эвдрэл гэмтэл, завсар зайдүй, асгарсан алдагдсан хаягдал, хуримтлагдсан хур тунадасны усыг тогтоон барих боломжтой хаалт, хашилттай байна;

9.2.2. алдагдсан болон хуримтлагдсан шингэнийг тогтоон барих хязгаарлалтын системийн эзлэхүүн нь уг суурин дээр байрласан савнуудын нийт эзлэхүүнээс эсвэл хамгийн том савны эзлэхүүнээс 10%-иар их байх.

9.3. Алдагдсан болон хуримтлагдсан шингэнийг хальж алдагдахаас урьдчилан сэргийлж, хураагуур эсвэл хязгаарлалтын системээс шингэн хуримтлагдсан тухай бүр нь зайлцуулж байна.

9.4. Аюултай хуурай хог хаягдал хадгалах сав байрлуулах талбай нь дараах шаардлагыг хангасан байна:

9.4.1. суурь нь налуу байх эсвэл хуримтлагдсан хур тунадасны усыг зайлцуулах, шавхах боломжтой байхаар төлөвлөгдөж, хийгдсэн байна;

9.4.2. аюултай хог хаягдал хадгалах сав нь хуримтлагдсан шингэнтэй хүрэлцэхгүй байхаар өргөгдсөн эсвэл хамгаалагдсан байна.

9.4.3. аюултай хог хаягдал хадгалах талбай нь хур тунадас, нарны шууд тусгалаас хамгаалсан дээвэртэй байна.

9.5. Шатамхай болон урвалын идэвхтэй хог хаягдал хадгалах савыг байгууламжийн доторх барилга байгууламжаас 15 метрээс багагүй зайд байрлуулна.

9.6. Нийцгүй хог хаягдал хадгалж байсан савыг цэвэрлэлгүйгээр өөр хог хаягдал савлахад ашиглахыг хориглоно.

9.7. Нийцгүй хог хаягдал хадгалж байгаа савыг бусад хог хаягдал хадгалж байгаа савтай ойр байрлуулсан бол далан суваг, хана гэх мэтээр тусгаарлаж, эрсдэл үүсэхээс хамгаална.

#### **Арав. Аюултай хог хаягдлыг ландфиллд булшилж устгахад тавигдах нэмэлт шаардлага**

10.1. Аюултай хог хаягдлын ландфилл нь Хог хаягдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

10.1.1. аюултай хог хаягдлын ландфиллын суурийн налуу нь 1 болон түүнээс дээш градус байна.

10.1.2. аюултай хог хаягдлын ландфилл нь дараах 2 үеэс бүрдсэн доторлогооны системтэй байна:

а/ дээд үе. ландфиллын ашиглалтын болон хаалтын дараах үеийн турш

хог хаягдлаас ялгараах хортой бодис нэвчихээс хамгаалах зориулалттай

материалаар (геомембран гэх мэт) хийгдсэн байна;

б/ доод нийлмэл үе. Энэ үе нь дараах 2 үеэс бүрдэнэ:

- нийлмэл үеийн дээд үе: ландфиллын ашиглалтын болон хаалтын дараах үеийн турш хог хаягдлаас ялгараах хортой бодис

нэвчихээс	хамгаалах	зориулалттай	материалаар
-----------	-----------	--------------	-------------

(геомембран гэх

мэт) хийгдсэн байна;

- доод үе: дээд үед гэмтэл гарснаас нэвчилт үүсэх үед шингэнийг

хязгаарлах зориулалттай материалыаар хийгдсэн байна. Энэ нь 90

см-ээс багагүй зузаантай, нэвчилтийн хурд нь  $1 \cdot 10^{-7}$  см/сек-ээс

ихгүй, нягтаршуулсан хөрс эсвэл шавран үе байна.

10.1.3. доторлогоо нь дараах шаардлагыг хангасан байна:

а/ доторлогооны материал нь хог хаягдал болон түүний шүүрэлд химийн

хувьд тэсвэртэй, даралтын зөрөө, цаг агаарын нөхцөл, суурилуулалт болон өдөр тутмын үйл ажиллагааны үед эвдэрч гэмтэхээргүй зузаантай,

бат бөх чанартай байх;

б/ ландфиллын суурь нь доторлогооны материалын дээр болон доороос

үзүүлэх даралтын зөрүүг тэсвэрлэхэд дэмжлэг үзүүлэхээр төлөвлөгджэж,

хийгдсэн байх;

в/ доторлогоо нь хог хаягдал болон түүний шүүрэлтэй хүрэлцсэнээс бохирдож болох газрын хөрсийг бүрэн бүрхсэн байх.

10.1.4. ландфиллын ашиглалтын хугацаанд болон түүнийг хаасны дараа хог хаягдлаас ялгараах шингэнийг цуглуулах, зайлуулах зориулалттай шүүрэл цуглуулах, зайлуулах системтэй байх ба доторлогооны дээр үеийн дээр байрлана.

10.1.5. ландфиллын шүүрэл цуглуулах, зайлуулах систем нь дараах шаардлагыг хангасан байна:

а/ шүүрэл цуглуулах, зайлуулах системийн зузаан нь 30 см-ээс ихгүй байх;

б/ландфиллд хуримтлагдсан хаягдал болон шүүрэлд химийн хувьд тэсвэртэй, хог хаягдлыг савласан сав болон ландфиллд ажиллаж байгаа

техник хэрэгслээс үзүүлэх даралтыг тэсвэрлэх зузаан, бат бөх чанартай

байх;

в/ ландфиллын ашиглалтын болон хаалтын дараах үед бөглөрөл хамгийн

бага байж, шүүрлийг чөлөөтэй нэвтрүүлэхээр төлөвлөгджэж, хийгдсэн байх.

10.1.6. ландфилл нь доторлогооны дээр үед үүссэн гэмтлээр шүүрэх шүүрлийг эрт үед нь илрүүлэх, түүнийг цуглуулах, зайлуулах зориулалттай

шүүрлийг мэдрэх системтэй байх ба шүүрлийг мэдрэх систем нь доторлогооны үеүдийн хооронд, доод нийлмэл үеийн дээр байрлана.

10.1.7. шүүрлийг мэдрэх систем нь дараах шаардлагыг хангасан байна:

а/ нэвчилтийн хурд нь  $1 \cdot 10^{-2}$  см/сек болон түүнээс дээш, үрэл хэлбэрийн материалаар хийгдсэн бол зузаан нь 30 см болон түүнээс дээш байх; эсхүл дамжуулах чадвар нь  $3 \cdot 10^{-5}$  м<sup>2</sup>/сек болон түүнээс дээш синтетик

геонет материалаар хийгдсэн байх;

б/ хог хаягдал болон түүний шүүрэлд химийн хувьд тэсвэртэй байх; в/ хог хаягдал болон түүнийг хучих материалаас үзүүлж болох даралт болон ландфиллд ажиллах техник хэрэгслээс үзүүлэх даралтыг хангалттай тэсвэрлэхээр зузаантай, бат бөх чанартай байх:

г/ ландфиллын ашиглалтын үед болон түүнийг хаасны дараа шүүрлийг мэдрэх системд үүсэх бохирдол бага байхаар төлөвлөгдж, хийгдсэн байх ба бохирдсоноос ажиллагаа нь алдагдахгүй байх нөхцөлийг хангасан байх;

д/ насос гэх мэт шингэнийг хөдөлгөх тоноглолоор тоноглогдсон байх;

е/ хангалттай эзлэхүүнтэй шүүрлийг цуглуулах хураагууртай байх; ё/ насос болон шүүрлийг цуглуулах хураагуур нь шингэний эзлэхүүнийг хэмжих, бүртгэх тоноглолоор тоноглогдсон байх.

10.2. Ландфиллын шүүрэл цуглуулах системээс үүссэн шингэнийг тухай бүр нь цуглуулж, зайлцуулж байна.

10.3. Ландфиллын үйл ажиллагаа эрхлэгч нь ашиглалтын явцад дараах бүртгэлийг хөтөлнө:

10.3.1. газрын зураг дээр булшилсан аюултай хог хаягдлын төрөл нэг бүрийн байрлал болон хэмжээ, гүнийг тэмдэглэж зураглал үйлдэж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

10.3.2. аюултай хог хаягдлын бүтэц, байршлын талаар тэмдэглэл хөтөлнө.

10.4. Ландфиллын үйл ажиллагаа эрхлэгч нь барилгын болон суурилуулалтын ажлын явцад доторлогооны системийн жигд байдал, гэмтэл, эвдрэл үүссэн эсэхэд (нүх, цууралт, толбо, нимгэрэлт, гадны биет гэх мэт) хяналт тавина.

10.5. Барилгын болон суурилуулалтын ажил дууссаны дараах хяналт шалгалтыг хийж баталгаа гаргана:

10.5.1. нийлэг доторлогооны материалын хувьд зүйдэл болон холболт зайд авсаргүй, бат бөх хийгдсэн эсэх болон цооролт, цууралт, цэврүү байгаа эсэх;

10.5.2. хөрсөн суурьт доторлогооны хувьд хонхор, гүдгэр, цууралт, ан цав, нүх сүв байгаа эсэх;

10.5.3. бүтцийн хувьд нэгэн төрлийн байгаа эсэх.

10.6. Ландфиллын ашиглалтын явцад хэвийн үед долоо хоногт нэг удаа, үер шуурга гэх мэт байгалийн гэнэтийн үзэгдэл бүрийн дараах хяналтыг тавина:

10.6.1. шүүрэл цуглуулах болон зайлцуулах системд эвдрэл гэмтэл, үйл ажиллагааны доголдол гарсан эсэх;

10.6.2. салхины хамгаалалт бүрэн бүтэн байгаа эсэх;

10.6.3. шүүрэл цуглуулах, зайлцуулах системд шүүрэл ялгарсан эсэх.

10.7. Ландфиллын ашиглалтын болон хаалтын үед хамгийн багадаа 7 хоногт 1 удаа шүүрэл цуглуулах системийн хураагуурт цугларсан шингэнийг хэмжиж, тэмдэглэл хөтөлнө.

10.8. Ашиглалтын эхний 1 жилийн хяналт-шинжилгээний дунд үндэслэн орон нутгийн төрийн захиргааны байгууллагаас шүүрлийн өрдийн түвшинг тогтоож, бичгээр баталгаажуулна.

10.9. Ландфиллыг бүрэн хаасны дараа хамгийн багадаа сард 1 удаа шүүрэл цуглуулах системд цугларсан шингэнийг хэмжиж, тэмдэглэл хөтөлнө. Хэрэв дараалсан 2 сарын турш цугларсан шингэний хэмжээ тогтмол байвал улиралд 1 удаа хийнэ. Хэрэв дараалсан 2 улиралд хийсэн хэмжилт тогтмол байвал жилд 1 удаа хэмжилт хийж, тэмдэглэл хөтлөнө. Хэрэв шүүрлийн хэмжээ өөрчлөгдвэл тогтмол болтол сард 1 удаа хэмжилт хийж, хяналт тавина.

10.10. Ландфиллын шүүрлийн системийн аль нэг хураагуурт шүүрэл өрдийн түвшингээс ихэссэн тохиолдолд ландфиллын үйл ажиллаагаа эрхлэгч нь дараах арга хэмжээг авна:

10.10.1. шүүрэл илрүүлснээс хойш 7 хоногийн дотор байгаль орчны асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

10.10.2. байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад

шүүрэл илрүүлснээс хойш 14 хоногийн дотор шингэний хэмжээ, шингэн үүсэж байж болох эх үүсвэр, түүний байршил, шалтгаан болон яаралтай авсан арга хэмжээ болон цаашид авах арга хэмжээний талаар анхан шатны үнэлгээ хийж, хүргүүлнэ.

10.10.3. шүүрэл үүсэж буй байршил, хэмжээ, шалтгааныг нарийвчлан тогтооно.

10.10.4. хаягдал хүлээн авахыг зогсоох эсвэл хүлээн авч буй хаягдлын хэмжээг

бууруулах арга хэмжээ авна.

10.10.5. тухайн газраас хог хаягдлыг зайлцуулж, доорх арга хэмжээний аль тохиорохыг авч хэрэгжүүлнэ:

а/ шалтгааныг илрүүлэн засварлах эсвэл,

б/ уг хэсгийг бүрэн хаах.

10.10.6. шүүрлийг зогсоох болон сааруулах урт болон богино хугацааны арга

хэмжээ авах шаардлагатай эсэхийг тогтооно.

10.10.7. шүүрлийг илрүүлснээс хойш 30 хоногийн дотор энэ хэсгийн 10.10.3, 10.10.4, 10.10.5-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн талаар болон түүнээс гарсан үр дүн, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хүргүүлнэ.

10.10.8. шүүрлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээс хойш сар бүр шүүрлийн хэмжээнд хяналт тавьж, тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хүргүүлж байна.

10.11. Ландфиллыг бүрэн болон хэсэгчлэн хаах ба хучилтын давхарга нь дараах шаардлагагыг хангасан байна:

10.11.1. хаагдсан, битүүмжлэгдсэн ландфиллээс удаан хугацаанд шингэн ялгарахгүй байх нөхцөлийг хангасан байх;

10.11.2. ландфилл хаагдснаас хойш түүнд тавих арчилгаа, үйлчилгээ хамгийн бага байх;

10.11.3. хур борооны ус болон элэгдэл, эвдрэлд хамгийн бага орохоор төлөвлөгджэх хийгдсэн байх;

10.11.4. тогтвортой, гулсалт нуралт үүсэхгүй байхаар төлөвлөгджэх хийгдсэн байх;

10.11.5. нэвчих чадвар нь ландфиллын суурийн доторлогооны нэвчих чадвартай ижил эсвэл түүнээс бага байх.

10.12. Ландфиллын үйл ажиллаагаа эрхлэгч нь хаалтын дараах хяналт шинжилгээг Хог хаягдлын тухай хуулийн 32.2-д заасан хугацаанд хийх ба дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

10.12.1. ландфиллын эцсийн хаалтын давхаргын тогтвожилт, бүрэн бүтэн байдлыг хангаж, гулсалт, элэгдэл, эвдрэл үүссэн тохиолдолд засварлах;

10.12.2. шүүрлийг цуглуулах, зайлцуулах үйл ажиллагааг дахин шүүрэл илрэхгүй болтол үргэлжлүүлэн хийх;

10.12.3. шүүрэл зайлцуулах системийн арчилгаа, үйлчилгээ болон хяналт-шинжилгээг хийх;

10.12.4. газрын доорх усны хяналтын цооногийн арчилгаа, үйлчилгээ болон газрын доорх усны хяналт-шинжилгээг хийх;

10.12.5. хур тунадасны урсацаас хамгаалах, үүссэн эвдрэл, гэмтлийн засварлах;

10.12.6. ландфиллд аюултай хог хаягдал булшлахад хөтөлсөн зураглал, тэмдэглэлийг хадгалах.

10.13. Чөлөөт шингэн агуулсан аюултай хог хаягдлыг ландфиллд булшлахын өмнө доорх төрлийн задардаггүй шингээгчийг ашиглаж шингэнийг зайлцуулна:

10.13.1. задардаггүй шингээгч:

а/ шавар, алюмосиликат, бентонит, монтмориллонит, каолин, вермуклет,

циолит, кальцийн карбонат (органик хольцгүй шохойн чулуу) гэх мэт органик биш эрдсүүд;

б/ хөнгөн цагааны исэл, шохой, цахиурын исэл (элс), перлит гэх мэт исэл, гидроксидууд;

в/ цементийн зуухны тоос;

г/ үнс;

д/ идэвхжүүлсэн нүурс.

10.13.2. биологийн гаралтай биш, задардаггүй өндөр молекулт нийлэг полимерүүд (полиэтилен, өндөр нягттай полиэтилен, полипропилен, полистерен, полиуретан, полиасрилат, полинорборен, полизиобутелен, синтетик резин гэх мэт);

10.13.3. био задралд ордоггүй материалуудын хольц.

10.14. Жижиг савтай аюултай хог хаягдлыг (лабораторийн химийн бодис гэм мэт) зориулалтын саванд савлаж, ландфиллд булшлахад дараах шаардлагыг хангасан байна:

10.14.1. аюултай хог хаягдлыг савласан сав нь асгарч гоожихооргүй бүрэн бүтэн, сайтар таглагдсан, дотор нь хадгалж байгаа хаягдалтай урвалд ордоггүй, задардаггүй, шаталт үүсгэдэггүй материалаар хийгдсэн байна.

10.14.2. жижиг савтай аюултай хог хаягдлыг 400 литрээс ихгүй хэмжээтэй металл торхонд савлаж, биозадралд ордоггүй, доторх хог хаягдалтай урвалд ордоггүй, задардаггүй шингээгч материалаар чижиж дүүргэсэн байна.

10.14.3. хоорондоо нийцгүй хог хаягдлыг нэг саванд хийж булшилахыг хориглоно.

#### **Арван нэг. Аюултай хог хаягдал шатааж устгахад тавигдах нэмэлт шаардлага**

11.1. Аюултай хог хаягдал шатааж устгахад Хог хаягдлын тухай хуулийн 35 дугаар зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг мөрдөнө:

11.1.1. Аюултай хог хаягдал шатаах үйл ажиллагааны горим, технологийн үзүүлэлтийг тогтоох туршилтын шатаалтаар доорх үзүүлэлтүүдийг тодорхойлж, бүртгэл хөтөлнө:

- а/ хаягдал дахь аюултай органик үндсэн бүрэлдэхүүн (АОУБ);
- б/ яндангаас гарах утааны хий дэх аюултай органик үндсэн бүрэлдэхүүн,
- хүчилтөрөгч ( $O_2$ ), хлорт устэрөгч (HCl);
- в/ үнс, скруберийн ус болон бусад үлдэгдлийн найрлагын тоон шинжилгээ;
- г/ утааны хий дэх тоосны хэмжээ;
- д/ шатаалтын хийн хурд, температур (тасралтгүй хэмжилтээр) ;
- е/ яндангаас гарах утааны хий дэх нүүрстөрөгчийн моноксидын (CO) агууламж (тасралтгүй хэмжилтээр);
- ё/ зориудын бусаар үүсдэг удаан задардаг органик бохирдуулагч.

11.2. Энэ журмын 11.1.1-д заасан хэмжилтийн дүнд үндэслэн дараах үзүүлэлтийг тодорхойлно:

11.2.1. Туршилтын шатаалтын үед хянах шаардлагатай, хог хаягдалд агуулагдах хэмжээ нь өндөр, шатааж устгахад хүндрэлтэй аюултай бүрэлдэхүүнийг аюултай органик үндсэн бүрэлдэхүүн (АОУБ) гэх бөгөөд аюултай хог хаягдал шатаах зуухны АОУБ-ийг задлах чадварыг дараах томъёогоор тооцоолно:

$$\text{ЗЧ} = \frac{(\text{АОУБ}_{\text{хог}} - \text{АОУБ}_{\text{утааны хий}})}{\text{АОУБ}_{\text{хог}}} \times 100\%$$

ЗЧ – задлах чадвар

АОУБ<sub>хог</sub> – хог хаягдал дахь аюултай органик үндсэн бүрэлдэхүүн хэмжээ

АОУБ<sub>утааны хий</sub> – утааны хий дэх аюултай органик үндсэн бүрэлдэхүүн хэмжээ

11.2.2. Утааны хий дэх тоосны хэмжээг хий дэх хүчилтөрөгчийн хэмжээнээс хамааруулж дараах томъёогоор тооцоолно:

$$P_c = P_m \times \frac{14}{21 - Y}$$

P<sub>m</sub> – утааны хийд хэмжсэн тоосны хэмжээ

Y- утааны хийд хэмжсэн хүчилтөрөгчийн хэмжээ

11.3. Аюултай хог хаягдал шатаах үйл ажиллагаа эрхлэгч нь туршилтын шатаалтын үр дүнд үндэслэн үйл ажиллагааны горим болон технологийн үзүүлэлтүүдийг тогтооно.

11.4. Аюултай хог хаягдал шатаах зуухны үйл ажиллагааны үзүүлэлтүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

11.4.1. УАОБ-ийг задлах чадвар 99,99%-д хүрсэн байх;

11.4.2. Утааны хий дэх тоосны хэмжээг хуурай стандарт шоо метрт 180 миллиграммас ихгүй байх;

11.5. Аюултай хог хаягдал шатаах зуухнаас ялгараах хийд хлорт устэрөгчийн агууламж цагт 1.8 кг –аас их байвал хлорт устэрөгчийн ялгарлыг хянах арга хэмжээ авна.

11.6. Аюултай хог хаягдлыг шатааж устгах үйл ажиллагаа эрхлэгч нь өмнө нь хүлээн авч, шатааж устгаж байгаагүй хог хаягдлыг хүлээж авахдаа гэрээнд заасан хог хаягдлын төлөөлөх дээжинд шинжилгээ хийж найрлага, бүтцийг тогтоохоос гадна доорх үзүүлэлтийг заавал тодорхойлж, бүртгэл хөтөлж баримтжуулна:

11.6.1. хаягдлын илчлэг;

11.6.2. хаягдал дахь галоген болон хүхрийн агууламж;

11.6.3. хаягдал дахь хартугалга, мөнгөн усны агууламж.

11.7. Аюултай хог хаягдал шатаах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны горимын дагуу шатаалтыг явуулна.

11.8. Зууханд шатаалтыг эхлүүлэхдээ зуухны үйл ажиллагаа тогтмолжиж, температур болон агаарын урсгал тогтвортол цэвэр түлшээр ажиллуулах ба үйл ажиллагаа тогтвортвоогүй байхад хог хаягдлыг зууханд ачаалахыг хориглоно.

11.9. Зуухыг зогсоохдоо зуухан дахь хог хаягдал бүрэн шатааж дууссаны дараа шатаалтыг зогсоох үйлдлийг эхлүүлнэ.

11.10. Зууханд өгөх хог хаягдлын ачаалалт болон зуухны бүтэцэд өөрчлөлт гарах, зуухны үйл ажиллагааны үзүүлэлтүүд зөвшөөрөгдсөн хэмжээний хязгаараас гарсан тохиолдолд зуухны үйл ажиллагааг зогсооно.

11.11. Аюултай хог хаягдал шатаах зуух нь шаталт болон ялгаралд хяналт тавих төхөөрөмжтэй байх ба уг төхөөрөмж нь дараах шаардлагыг хангасан байна:

11.11.1. хамгийн багадаа 15 минут тутамд хэмжилт хийж бүртгэдэг байх;

11.11.2. хэмжилтээр шатаалтын параметрт өөрчлөлт гарсан тохиолдолд автоматаар эсвэл оператор нэн даруй тохиргоо хийж хэвийн үйл ажиллагааг хангах боломжтой байх;

11.11.3. шаталт болон ялгаралд хяналт тавих төхөөрөмж нь хог хаягдлын болон нэмэлт түлшний өгөлт, агаарын урсгал, шатаалтын температур, хийн цэвэрлэгээний скрубберийн урсгал болон pH гэх мэт шаардлагатай параметруүдийг хянах боломжтой байх.

11.2. Шатаалтын зуух болон дагалдах тоног төхөөрөмжийн (насос, хавхлага, дамжуулагч, шугам хоолой) үйл ажиллагаанд хамгийн багадаа өдөрт нэг удаа доорх хяналт тавина:

11.2.1. асгаралт, алдагдал;

11.2.2. ялгарал;

11.2.3. осол аваарын үед ажиллах хяналтын болон дохиоллын системийн ажиллагаа.

11.3. Аюултай хог хаягдлыг шатааж устгах үйл ажиллагаа эрхлэгч нь байгууламжийн үйл ажиллагаг зогсоож хаахдаа шатаалтын зуухнаас бүх хог хаягдал болон хог хаягдлын үлдэгдлийг (үнс, скрубберийн ус болон лаг гэх мэт) зайлцуулна.

**Арван хоёр. Аюултай хог хаягдал устгах, хадгалах, дахин боловсруулах үйл ажиллагаанаас үүсэх ялгарлыг хянах системд тавигдах шаардлага**

12.1. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах байгууламжийн үйл ажиллагаанаас үүсэх ялгарлыг хянах систем нь Хог хаягдлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

12.2. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах байгууламжийн ажлын байр, агуулах зэрэг битүү орчны агаарыг сэлгэх агааржуулалтын нэгдсэн системтэй байх ба уг системээс гарсан агаарыг дараах аргаар зайлцуулна:

12.2.1. шатаалтын зууханд өгч буй агаартай нийлүүлж шатаах;

12.2.2. цэвэршүүлж агаарт хаях.

12.3. Агаарт ялгараах ялгаралд хяналт тавих системтэй байх ба хэмжилтийг тасралтгүй эсвэл тогтоосон хугацаанд хийж, үр дүнг бүртгэдэг байна.

12.4. Аюултай хог хаягдал устгах, дахин боловсруулах байгууламж нь нэрэх, ууршуулах, уусгагчаар хандлах п роцесс, хий болон уур цэвэрлэх систем зэргээс үүссэн хүнд болон хөнгөн шингэн хаягдлыг цуглуулах, хуримтлуулах тоноглогдсон байна.

## **Арван гурав. Тайлагнах**

13.1. Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тайлангаа байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан маягтын дагуу гаргана.

13.2. Энэ журмын 13.1-д заасан тайланг Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журамд заасан байгууллагад, заасан хугацаанд хүргүүлнэ.

о о О о о